

**ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРИЙГ ХӨГЖҮҮЛЭХ, БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ХОЁР-
ҮЕ ШАТТАЙ ЗЭЭЛИЙН ТӨСЛИЙН ХОЁР ДАХЬ ШАТНЫ ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

(2020 оны жилийн эцсийн байдлаар)

2021 оны 02 дугаар сарын 26

№	Хөтөлбөр/төслийн агуулга	Гүйцэтгэл
1.	Төсөл, хөтөлбөрийн нэр, огноо, шийдвэрийн дугаар (Жич: уялдаа холбоо бүхий дэд/төсөл, хөтөлбөр байвал нэгтгэн тайлагнана)	<p>Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах хоёр-үе шаттай зээлийн төслийн хоёр дахь шат [MON-P9]</p> <p>МУЗГ, Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага хооронд байгуулсан Зээлийн гэрээ батлагдсан огноо: 2010.11.19 Төсөл хэрэгжих хугацаа: 2011.06.03 – 2015.05.30</p> <p>Төслийн зорилго:</p> <ul style="list-style-type: none"> - Эдийн засгийн өсөлтийг дэмжих, ядуурлыг бууруулах, тогтвортой хөгжлийг бий болгох - Жижиг дунд бизнес эрхлэгчдэд урт хугацааны санхүүгийн дэмжлэг үзүүлэх замаар хувийн хэвшлийг хөгжүүлэх - Байгаль орчныг хамгаалах - Жижиг дунд бизнес эрхлэгчид болон төсөлд оролцогч банкуудыг чадавхжуулах
2.	Санхүүжилтийн эх үүсвэр	Хөнгөлөлттэй зээл (иенийн эх үүсвэр)
3.	Хэрэгжүүлэгч байгууллага/ хэрэгжих нийт хугацаа	<p>Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага: Сангийн яам</p> <p>Хамтран хэрэгжүүлэгч байгууллага: ЯОУХАБ</p> <p>Хэрэгжих нийт хугацаа: 2011.06.03 - 2018.05.30</p>
4.	<p>Төсөл, хөтөлбөрийн зорилтууд</p> <p>Зорилт 1: Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх бүрэлдэхүүний хүрээнд:</p> <p>Зорилт 2: Байгаль орчныг хамгаалах бүрэлдэхүүний хүрээнд:</p> <p>Зорилт 3: Төсөлд оролцогч банкуудын чадавхыг сайжруулах:</p>	<p>А. Санхүүжигдсэн төслийн зээлийн тоо 170 ба түүнээс дээш байх</p> <p>Б. Санхүүжигдсэн төслийн мөнгөн дүн (ам.доллар) 55 сая ба түүнээс дээш байх</p> <p>В. Төслийн хүрээнд нэмэгдсэн ажлын байрны тоо төсөл хэрэгжиж эхлэхээс өмнөх үетэй харьцуулахад тодорхой хэмжээгээр өссөн байх</p> <p>Г. Урт хугацаат (3-аас дээш жил) зээлийн хэмжээ (%), тодорхой хэмжээгээр өссөн байх</p> <p>Д. Төслийн зээлдэгчдийн борлуулалтын өсөлт (%) тодорхой хэмжээгээр өссөн байх</p> <p>Е. Төслийн зээлдэгчдийн үйл ажиллагааны ашиг орлого (%) тодорхой хэмжээгээр өссөн байх</p> <p>Ё. Байгаль орчны төслийн хувьд нүүрсний хэмжээний бууралт (тнн/жил) төсөл хэрэгжиж эхлэхээс өмнөх үетэй харьцуулахад тодорхой хэмжээгээр буурах</p> <p>Ж. Байгаль орчны төслийн хувьд нүүрсхүчлийн хийн (CO₂) бууралт (тнн/жил) төсөл хэрэгжиж эхлэхээс өмнөх үетэй харьцуулахад тодорхой хэмжээгээр буурах</p> <p>З. Байгаль орчны төслийн хувьд NO_x, CO, SO₂-н ялгарлын бууралт (тнн/жил)</p> <p>И. Зуучлагч санхүүгийн байгууллагууд болон харилцагчид хийсэн сургалтын тоо 20 ба түүнээс дээш байх</p>

5.	Зардал	Төсөв (Нийт шаардагдах зардал)	Зээл: 5,000 сая иен (ам\$ 62.0 сая 2011 оны ханшаар)		
		Үүнд:	Төсөв (он) 2011-2016		Гүйцэтгэл
	ЖДҮ-н “А” данс		3,860,000.0	3,860,000.0	100
	Байгаль орчны “Б” данс		780,000.0	780,000.0	100
6.	Төсөл, хөтөлбөрийн зорилт:		Ажлуудын биелэлтийг доорх талбарт бичнэ.		
	1-р зорилтын хүрээнд: Хүрэх үр дүн:		Засгийн газраас баримталж буй бодлогын хүрээнд эдийн засгийг төрөлжүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх, ЖДҮ эрхлэгчдэд урт хугацааны санхүүгийн дэмжлэг үзүүлж, зээлд хамрагдсан аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг өргөжүүлэх, ашиг орлогоо нэмэгдүүлэх, эдийн засгийн өсөлтийг дэмжихэд Хоёр-үе шаттай зээлийн төсөл тодорхой хувь нэмэр оруулж байна. Төслийн явцад нийт 13,850 ажлын байр шинээр нэмэгдэж, 10,625 ажлын байрыг хадгалсан бөгөөд тайлант жилийн хугацаанд 460 ажлын байр хадгалж, 280 ажлын байр шинээр бий болгох нөхцөлийг бүрдүүлсэн байна. Төслийн зээлд хамрагдсан жижиг дунд бизнес эрхлэгчид үйл ажиллагаагаа өргөтгөх, бүтээгдэхүүн/үйлчилгээний чанарыг сайжруулах, зах зээлд эзлэх байр сууриа нэмэгдүүлэх боломж бүрдсэн байна.		
	А. Санхүүжигдсэн төслийн зээлийн тоо 170 ба түүнээс дээш байх		2020 оны 12-р сарын 31-ний байдлаар нийт 894 төслийг санхүүжүүлж, үүнээс тайлант онд 24 дэд-төслийг 12 орчим тэрбум төгрөгийн санхүүжилтийг эргэн төлөлтийн сангаас санхүүжүүлсэн байна.		
	Б. Санхүүжигдсэн төслийн мөнгөн дүн (ам.доллар) 55 сая ба түүнээс дээш байх		2020 оны 12-р сарын 31-ний байдлаар нийт 894 дэд-төслийг 318.8 тэрбум төгрөг ¹ буюу 908.5 сая ам.долларыг санхүүжүүлж, тайлант онд 24 дэд-төслийг 4.2 сая ам.доллар буюу 12.0 тэрбум төгрөгөөр санхүүжүүлсэн байна.		
	В. Төслийн хүрээнд нэмэгдсэн ажлын байрны тоо төсөл хэрэгжиж эхлэхээс өмнөх үетэй харьцуулахад тодорхой хэмжээгээр өссөн байх		2019 оны 12-р сарын 31-ний байдлаар нийт 23,735 ажлын байр бий болсон, 2020 онд 280 ажлын байр шинээр бий болж, 460 ажлын байр хадгалж нийт 24,475 бий болсон байна.		
	Г. Урт хугацаат (3-аас дээш жил) зээлийн хэмжээ (%-аар), тодорхой хэмжээгээр өссөн байх		Төслийн санхүүжилтийг дунджаар 7 жилийн хугацаатай (үндсэн зээлээс чөлөөлөгдөх хугацаа 1-2 жил) – гаар олгосон тул зах зээл дэх урт хугацаат зээлийн хувь хэмжээ нэмэгдэхэд тодорхой хувь нэмэр оруулж байна.		
	Д. Төслийн зээлдэгчдийн борлуулалтын өсөлт (%) тодорхой хэмжээгээр өссөн байх		Төсөлд хамрагдсан зээлдэгчдээс авсан түүвэр судалгааны ² үр дүнгээр төсөлд хамрагдсан ААН-ийн борлуулалт дунджаар 30%-аар өссөн дүн гарсан.		
	Е. Төслийн зээлдэгчдийн үйл ажиллагааны ашиг орлого (%) тодорхой хэмжээгээр өссөн байх		Төсөлд хамрагдсан зээлдэгчдээс авсан түүвэр судалгааны ³ үр дүнгээр төсөлд хамрагдсан ААН-үүдийн үйл ажиллагааны ашиг орлогын хэмжээ дунджаар 30%-аар өссөн дүн гарсан. ХШҮ-90%		
2-р зорилтын хүрээнд: Хүрэх үр дүн: Санамж: Хүрэх гол үр дүнг бичнэ.		Хоёрдугаар зорилтын хүрээнд, байгаль орчны дэд-төслүүдийг хөнгөлөлттэй зээлээр санхүүжүүлэх замаар Монгол улсад тулгамдаж буй байгаль орчны асуудал болох хот суурин газрын агаарын бохирдлыг бууруулахад тодорхой хувь нэмэр оруулж байна. Агаарын бохирдлыг бууруулах, эрчим хүч (нар, салхины эрчим хүч) үйлдвэрлэх төслүүдийг санхүүжүүлэхээр тусгагдсан нь зээлийн үр нөлөөг нэмэгдүүлсэн байна.			

¹ Тусгай данс болон эргэн төлөлтийн сангаас санхүүжүүлсэн нийт дүн

² Төслийн зөвлөх нэгжийн 2015 оны 6 дугаар сард хийгдсэн судалгааны тайлан

³ Төслийн зөвлөх нэгжийн 2015 оны 6 дугаар сард хийгдсэн судалгааны тайлан

<p>Ё. Байгаль орчны төслийн хувьд нүүрсний хэмжээний бууралт (тнн/жил) төсөл хэрэгжиж эхлэхээс өмнөх үетэй харьцуулахад тодорхой хэмжээгээр буурах</p>	<p>Төсөл хэрэгжих хугацаанд БОХ чиглэлийн нийт 106 дэд-төслийг 13.7 сая ам.доллар буюу 39.1 тэрбум төгрөгөөр санхүүжүүлсэн байна. Эдгээр дэд-төслүүдийн хэрэгжилтийн хүрээнд түүхий нүүрсний хэрэглээг жилдээ 118,006.82⁴ тонноор бууруулдаг гэсэн мэдээтэй байна. Энэ нь төсөл хэрэгжүүлэхээс өмнөх үетэй нь харьцуулахад даруй 61,675.07 тонноор бага байна.</p>
<p>Ж. Байгаль орчны төслийн хувьд нүүрсхүчлийн хийн (CO₂) бууралт (тнн/жил) төсөл хэрэгжиж эхлэхээс өмнөх үетэй харьцуулахад тодорхой хэмжээгээр буурах</p>	<p>Дээрх 106 дэд-төслүүдийн хэрэгжилтийн хүрээнд нүүрсхүчлийн хийн ялгаруулалт жилд 320,077.42 тонноор буурсан байна. Төсөл хэрэгжүүлэхээс өмнөх үетэй харьцуулахад 134,595.66 тонноор бууруусан мэдээтэй байна.</p>
<p>З. Байгаль орчны төслийн хувьд NO_x, CO, SO₂-н ялгарлын бууралт (тнн/жил)</p>	<p>БОХ чиглэлийн төслүүдийн хэрэгжилтийн хүрээнд бууруулсан азотын хийн хэмжээ жилдээ 584.52 тонн, хүхрийн хийн хэмжээ 422.19 тонн, тоосонцорын хэмжээ 12,697.69⁵ тонн жингээр тус тус буурсан байна. ХШҮ- 82%</p>
<p>3-р зорилтын хүрээнд: Хүрэх үр дүн:</p>	<p>ТХН-ийн зүгээс тогтмол сургалт зохион байгуулан ажилласны үр дүнд ЗСБ-ууд урт болон богино хугацааны зээлийн төслийн судалгааг хийх чадвартай болсон. ЖДҮ эрхлэгчдийг чадавхжуулах ажлын хүрээнд, зээл хүсэгч аж ахуйн нэгжүүд нийгэм, эдийн засгийн ач холбогдол бүхий төсөл, бизнес төлөвлөгөө төсөл бичих, төслөө төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэх чадвартай болсон. Ингэснээр, ААН-ийн санхүүгийн сахилга бат сайжирч Хоёр-үе шаттай зээлийн төслийн зорилго, зорилтууд биелэх таатай нөхцөл бүрдэж байна.</p>
<p>И. Зуучлагч санхүүгийн байгууллагууд болон харилцагчид хийсэн сургалтын тоо 20 ба түүнээс дээш байх</p>	<p>- 2020 оны 12-р сарын 31-ний байдлаар ЗСБ-ууд 60 удаагийн сургалтаар 1,193 хүн; - Зээл хүсэж буй аж ахуйн нэгжүүдэд нийт 117 удаагийн сургалтаар 2,429 хүн тус тус хамрагдсан байна. ХШҮ-90%</p>
<p>7. Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарах асуудлууд)</p>	<p>Хоёр-үе шаттай зээлийн төсөл хэрэгжсэнээр дараах үр дүнд хүрсэн байна.</p> <ul style="list-style-type: none"> ▪ 894 ААН-үүдэд 318.8 тэрбум төгрөгийн зээл олгосон; ▪ Байгаль орчныг хамгаалах чиглэлээр 106 дэд төслийг 39.1 тэрбум төгрөгөөр санхүүжүүлсэн; ▪ 13,850 ажлын байр шинээр бий болсон; ▪ ЖДБ эрхлэгчдийн ашиг орлого нэмэгдсэн; ▪ ЖДБ эрхлэгчдэд 117 удаагийн сургалтаар 2,429 хүн, ЗСБ-д 60 удаагийн сургалтаар 1,193 эдийн засагч нарыг сургалтад хамруулсан зэрэг үр дүнд хүрсэн байна.
<p>8. Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ</p>	<p>ТХН-д харилцан хамааралтай оролцогч талууд болох СЯ, ЖАЙКА ОУБ, ТУХ, зуучлагч санхүүгийн байгууллагуудад төслийн зорилго, зорилтын талаарх танилцуулга, мэдээлэл, зөвлөмжийг цаг тухай бүрд нь өгч, ажил хэргийн уулзалтыг удаа дараа зохион байгуулсан байна.</p> <p>Өнгөрсөн 2019, 2020 оны 8 дугаар саруудад ЯОУХАБ-аас нэг сарын хугацаагаар хөндлөнгийн үнэлгээний баг ирүүлж, ХҮШЗТ анхны зорилт, зорилгодоо хүрсэн эсэх, төслийн үйл ажиллагааны явц, хүрсэн үр дүн зэргийг судлан урдчилсан байдлаар “Маш сайн” үнэлгээ өгсөн бөгөөд албан ёсны тайланг 2020 оны 4 улиралд ирүүлсэн.</p> <p>Төсөлд оролцогч санхүүгийн зуучлагч байгууллагууд болох банкууд шалгуур үзүүлэлтүүдээ ханган ажиллаж байгаа эсэх талаар хяналт тавих ажилд ХХААХҮЯ, ТУХ-той ТХН хамтран ажиллаж харилцагч 6 банктай байгуулсан Дамжуулан зээлдүүлэх гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах, 1 банктай</p>

⁴ ТХН-ийн хийсэн тооцоолол

⁵ ТХН-ийн хийсэн тооцоолол

			дамжуулан зээлдүүлэх гэрээг шинээр байгуулах бэлтгэл ханган ажиллаж байна.			
9.	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт (Өөрийн үнэлгээ)	Биелэлт дундаж	Зорилтын тоо	Зорилт 1	Зорилт 2	Зорилт 3
		86.7	3	90	82	90
10.	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ (ЗГХЭГ-ын үнэлгээ)	Нэгдсэн үнэлгээ				
		... %				

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ